



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 334

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх ┐ зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Дундговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар)-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 44,300,000.00 (дөчин дөрвөн сая гурван зуун мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, Дундговь аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга (Д.Нарангэрэл), Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Адъяасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хавсралтад заасан хөрөнгийг эзэмшүүлэх этгээдийг тогтоож, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, засаж сэлбэн ашиглах, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005673

17-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн
189 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
(ДУНДГОВЬ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР)-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСЧ,
ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ АВТОМАШИН**

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/аш иглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Лексус-470, 00-06 ДУА, JT6HT00W2W0023925	1998/2001	44,300,000.00	44,300,000.00	-
	НИЙТ ДҮН		44,300,000.00 (дөчин дөрвөн сая гурван зуун мянган)	44,300,000.00 (дөчин дөрвөн сая гурван зуун мянган)	-